



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 404

Ховд

П.Цэцэгсүрэнг ажлаас чөлөөлж,
ажилд томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1.1 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. П.Цэцэгсүрэнг өөрийнх нь хүсэлтийг үндэслэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Авлигын эсрэг үйл ажиллагаа, хууль тогтоомжийн хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтний албан тушаалаас 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрөөр тасалбар болгон чөлөөлж, мөн өдрөөс эхлэн тус хэлтсийн Эрх зүйн сургалт сурталчилгаа, хууль тогтоомжийн системчлэл, лавлагаа сан хариуцсан мэргэжилтнээр томилсугай.

2. П.Цэцэгсүрэнд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээ”-ний ТЗ-5-5 дахь шатлал буюу 791532 төгрөг /долоон зуун ерэн нэгэн мянга таван зуун гучин хоёр/-өөр цалинжуулж, хууль тогтоомжид заагдсан холбогдох нэмэгдлүүдийг сар бүр бодож олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын ерөнхий нягтлан бодогч /Б.Нямдэлгэр/-д зөвшөөрсүгэй.

3. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

4. П.Цэцэгсүрэнд албан тушаалын тодорхойлолтод заасан ажил үүргийг хариуцуулан удирдлагаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Н.Ганзориг/-д даалгасугай.

ДАРГА



Д.ЭНХБОЛД